

## ТАНИЛЦУУЛГА

“Журам шинэчлэн батлах тухай”  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
сайдын тушаалын төсөл  
боловсруулсан тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль 2008 онд УИХ-аар батлагдаж, тус хуулийн 31.3-д “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”, гэж заасны дагуу “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх тухай журам”-г Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаалаар баталж, мөрдөн ажиллаж байна.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхийн гол зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ажлын байрны орчинд нөлөөлөх хими, физикийн хүчин зүйлийг тодорхойлох, эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх, газрын дор, хортой, халуун, хүнд нөхцөлийг тодорхойлон хэмжилт, судалгаа хийх, үнэлгээ өгөх, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгоход оршдог.

Одоо мөрдөгдөж байгаа Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаал нь 4 зүйлтэй бөгөөд 3 дугаар зүйлийн 3.6 дахь заалтыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 221/ШШ2019/0015 дугаар шийдвэрээр хүчингүй болсон бөгөөд аж ахуйн нэгж байгууллагуудын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх итгэмжлэл бүхий мэргэжлийн байгууллагуудын тоог нэмэгдүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны орчныг сайжруулан эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгоход анхаарч ажиллахыг нөхцөл байдал шаардаж байна. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн ангилал, үнэлгээнд тавих ерөнхий шаардлага стандарт 2023 оны 6 дугаар сард Стандарт, хэмжил зүйн газрын даргын С/24 дүгээр тушаалаар батлагдсан.

Иймд уг журмыг одоогийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн боловсруулах зайлшгүй шаардлагатай гэж үзсэн.

Энэхүү журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/42 дугаар тушаалаар баталж, журмыг хэрэгжүүлэгч болон оролцогч талуудаас санал авч, саналуудыг журмын төсөлд тусган боловсрууллаа.

Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн боловсруулж, шинээр хариуцлага, хяналт, цахим мэдээллийн сангийн талаарх зохицуулалтуудыг нэмж оруулсан. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/75 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үнэлгээ хийх жишиг үнэ”-ийг тус журмын хавсралтаар баталж байна. Ингэснээр 4 зүйл 23 заалттай байсан журмыг 6 зүйл 43 заалттай болгон шинэчлэн боловсруулсан.

Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж санал авна” гэж заасны дагуу ХНХЯ-ны вэб сайтад 2022 оны 11 дүгээр сараас хойш байршуулан олон нийтэд танилцуулж, санал авсан. Мөн Улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр нөлөөллийн шинжилгээг хийсэн болно.

Журмын төсөлд Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс санал авахаар 2023.10.03-ны 02/2462, 2023.10.10-ны 02/2543 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн бөгөөд Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөс журмын төсөлд тусгайлан өгөх саналгүй тухай хариуг ирүүлээд байна.

*Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд хийх үнэлгээний тарифыг шинэчлэхдээ:*

- Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд хэмжилт хийх химийн бодисын стандарт аргазүйд ашиглагдах багаж тоног төхөөрөмж, урвалжийн нэг бүрийн үнийн тооцоолол;
- Ажлын байрны агаарт үзэх химийн бодисын нэр төрлийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг 26 аж, ахуйн нэгж байгууллагын ашигладаг химийн бодисын судалгаа хийж, БОАЖ-ын яамнаас ирүүлсэн Монгол улсад бүртгэлтэй химийн бодисын жагсаалттай харьцуулан, ЭМЯ, ХХААХҮЯ, МУИС-ын Дотоод орчны судалгааны хамтлагаас ирүүлсэн санал;
- Ижил төстэй байгууллагын “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд хийх хэмжилт, шинжилгээний ажлын үнэ” (МХЕГ-ын даргын 2012 оны 211 тоот тушаал), “Ногоон титэм” шинжилгээний лабораторийн үнийн жагсаалт;
- ОХУ болон АНУ-ын агаарын шинжилгээний үнийн жагсаалт;
- Оросын холбооны улсын ижил төстэй байгууллагын үнийн жагсаалт;
- “Байгаль орчин, хөдөлмөр хамгааллын шинжлэх ухаан - үйлдвэрлэлийн төв”-ийн лабораторийн үнийн жагсаалт;
- Баруун-Хойд зүгийн хөдөлмөр хамгааллын төв лабораторийн үнийн жагсаалт;
- “АНУ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон байгаль орчны нөлөөлөл”-ийг тооцоолдог аналитик шинжилгээний лабораторийн үнийн жагсаалт;
- Монгол улсын өнөөгийн зах зээлийн үнийн судалгааг “Цэцүүх трейд” ХХК, “Грийн химистри” ХХК, “Сигма алдрич” химийн бодис, лабораторийн багаж хэрэглэлийн дэлгүүрийн багаж тоног төхөөрөмж, урвалжийн үнийн санал зэргийг тус тус үндэс болгов. Мөн одоогийн үнэ ханшны нөхцөл байдал, үнэлгээ хийх эрх бүхий байгууллагын тогтоосон үнэ болон нөхцөлийн үнэлгээ хийхэд ашиглагддаг багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэлтэй холбоотойгоор уялдуулан тарифыг шинэчилсэн.

